# МОНГОЛ УЛС
# ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 21 өдөр Дугаар А/391 Ховд

Агуулахын газрын байнгын
байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "г" дахь заалт, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Мөнх тэтгэгч хүч" ХХК-нд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах агуулахын газрын байнгын байршлыг Цэцэг сумын Хажинга багийн Алаг энгэрийн бэл хэмээх газарт тогтоож, тухайн газрын солбицлуудлыг хавсралтаар батлагсугай.

2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах агуулахын байрнд "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм" болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга П.Эрдэнэчулуунд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, агуулахын газрын байнгын байршлыг мэдээллийн нэгдсэн санд хуулийн хугацаанд бүртгүүлэхийг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповронд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Т.ЖАРГАЛСАЙХАН

02 01913

Zax A/391 Ch

Аймгийн Засаг даргын 2019 оны
06 дугаар сарын 21-ний өдрийн
А/391 дүгээр захирамжийн хавсралт

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙГ ХАДГАЛАХ АГУУЛАХЫН ГАЗРЫН БАЙНГЫН БАЙРШИЛ

| # | X | Y |
|---|---|---|
| 1. | 524180.09 | 5173500.01 |
| 2. | 524237.02 | 5173600.37 |
| 3. | 524350.10 | 5173536.23 |
| 4. | 524293.17 | 5173435.87 |

-oOo-